



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2016 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

Тээвэрлэлтийн чиглэл тогтоох тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Автотээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сүхбаатар аймгийн Уулбаян сумын нутагт орших Цахиурт-Овоогийн уурхайгаас Бичигт-Зүүн хатавч хилийн боомтын чиглэлд төмрийн хүдэр тээвэрлэх улс хоорондын тээвэрлэлтийн чиглэлийг "Авто замын чиглэл батлах тухай" Зам, тээврийн сайдын 2015 оны 267 дугаар тушаалаар батлагдсан координатын дагуу болон Баруун Урт-Бичигт-Улсын хил чиглэлийн улсын чанартай А2001 дугаар авто замаар тээвэрлэхээр тогтоосугай.

2. Тухайн тээвэрлэлтийн чиглэлийн авто замын засвар арчлалтыг бүрэн хариуцаж, тээвэрлэлтийг "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598:2011" стандартад нийцүүлэн зохион байгуулахыг "Эм Эл Цахиурт Овоо" ХХК-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Авто замын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Доржханд/, Сүхбаатар аймгийн Засаг дарга /Ж.Батсуурь/, тогтоосон чиглэлд "Эм Эл Цахиурт Овоо" ХХК-ийн санал болгосон тээвэрлэгч аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажиллахыг "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ /Н.Пунцаг/-т тус тус даалгасугай.

САЙД



М.ЗОРИГТ